

3. Ya tai yang jiu, Beijing (Ази Номхон далайн судлал, Бээжин, 1984, № 1, 5-р тал
4. Su, Cao, ri dui wai jing ji guang si., Jilin., Зөвлөлт, Өмнөд Солонгос, Японы гадаад эдийн засгийн харилцаа, Жилин, 1988, 351-р тал.
5. Wai guo wen ti yang jiu Jilin., (Гадаад орнуудын асуудлын судалгаа), 1990, № 2, е—2.
6. Мөн тэнд.
7. Di li yang jiu, Beijing., (Газар зүйн судлал), Бээжин, 1989, № 12, е—73.
8. Wai guo wen ti yang jiu, Jilin., (Гадаад орнуудын асуудлын судалгаа), 1990, № 2, е—5.
9. Guo ji wen ti yang jiu Beijing., (Олон улсын асуудлын судлал). 1985. № 4, 11-р тал

МОНГОЛ ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦАА

А. Буянтөгс

БНМАУ, Япон улсын хооронд 1972 оны 2-р сарын 24-нд дипломат харилцаа тогтоосноос хойш 20 жил боллоо. Энэ түүхт ойг хоёр тал саяхан ёслол төгөлдөр тэмдэглэв.

Энэ хугацаанд хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа хоёр талын идэвхитэй үйл ажиллагааны үрээр өргөжин хөгжиж ирлээ. 1972 онд худалдааны нийт эргэлт 1,1 сая. ам. доллар байсан бол 1991 онд 21,1 сая. ам. долларт хүрч даруй 19,2 дахин өсөв.¹ Өнгөрсөн жилүүдэд Монголоос малын төрөл бүрийн ноос, ноолуур, тэмээний ноос, адууны дэл, сүүл, сүлжмэл эдлэл, боловсруулсан ноолуур, зэсийн баяжмал зэрэг барааг Японд экспортлож, оронд нь Японоос өргөн хэрэгцээний бараа, өнгөт телевизор, магнитофон, түүний кассет, цахилгаан хөдөлгүүр, усны насос (шахуурга) үйлдвэрийн зарим түүхий эд материал, тоног төхөөрөмж зэрэг барааг худалдан авч байсан, авч байна. Ийм худалдаануудыг үе үе хийж ирсэн нь Монгол, Японы худалдаа, эдийн засгийн харилцааг өргөтгөхөд чухал нөлөө үзүүлэв.

1977 онд байгуулсан эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрээр жилдээ 100 тонн ямааны ноолуур, 200 тонн тэмээний ноос боловсруулах орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон «Говь» комбинатыг Японы засгийн газраас буцалтгүй олгосон хөрөнгөөр барьж 1981 онд ашиглалтанд оруулсан нь манай экспортод чухал ач холбогдолтойгоор барахгүй, хоёр орны эдийн засгийн харилцааны анхны томоохон үр дүн болсон юм. Сүүлийн жилүүдэд Монгол оронд ардчилал, шинэчлэл хөгжиж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үеийн эдийн засгийн бэрхшээл тохиолдож байгаа нөхцөлд манай улсын сайд нарын зөвлөлийн дарга 1990 онд Японд, Японы ерөнхий сайд 1991 онд Монголд айлчилснаар хоёр орны эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг идэвхитэй хөгжүүлэх сайхан бололцоо нээгдэж, Япон улсаас манай улсад үзүүлэх эдийн засгийн зээл, туслалцааны хэмжээ эрс өргөжиж байна. Монголын эдийн засгийн өнөөгийн хямралтай хүнд байдлыг даван туулахад зориулж Японы засгийн газраас 15 сая ам. долларын буцалтгүй тусламж, 35 сая ам. долларыг тодорхой төсөлтэй холбохгүйгээр олгосон юм.² 15 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр ард түмний өргөн

¹ А Буянтөгс —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн.

хэрэгцээний зарим бараа, нүүрсний салбарт хүнд даацын өөрөө буулгагч автомашин (самосвал), бульдозер, тээврийн салбарт автомашины төрөл бүрийн дугуй, аккумулятор, химийн зарим болон барилгын 10-аад нэрийн материалыг манай захиалгын дагуу бүрэн шийлүүлээд байна. Японоос тусалсан 35 сая долларын хөнгөлттэй зээл нь манай орны түлш эрчим хүч, тээвэр, барилга, ХАА, эрүүл мэнд, хөнгөн аж үйлдвэр уул уурхай, холбооны салбарын сэлбэг материал, тоног төхөөрөмж, хүнсний болон өргөн хэрэглээний бараа, тослох материал авахад зарцуулагдаж, тус орны эдийн засгийн хүнд байдлыг хөнгөвчлөхөд зохих нөлөө үзүүлэх болно.

Өнөөгийн Япон улсын онцлог бол үндэсний орлогын нэг хүнд оногдох хэмжээгээрээ дэлхийд тэргүүн байр эзэлдэг, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр 2-р байранд ордог. Хүн амын хэрэгцээний 50 гаруй хувийг жижиг, дунд, үйлдвэрийн бүтээгдэхүүнээр хангадаг, үйлдвэрлэлийн уян хатан технологитой, өндөр зохион байгуулалт, дадлагатай, нийт хүмүүс нь улсаа хөгжүүлэх нэгэн зорилтонд нягтарч ажилладаг юм.

Энэ хөгжилтэй оронтой манай улс бүх талын, ялангуяа эдийн засгийн өргөн харилцаатай ажиллаж, тэдний тал бүрийн дэмжлэг тусалцааг авах нь манай орны өнөөгийн эдийн засгийн хүнд бэрхшээлийг давах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд түргэн шилжиж, эдийн засгаа тогтвортой хөгжүүлэхэд нэлээд их ач холбогдолтой болох нь гарцаагүй юм.

1. ГХЯ-ны тоо баримт.

2. «Үнэн», 1992. 2. 14. № 19.